

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 10 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 09 дүгээр сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно. Үүнд:

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн туршилтыг үе шаттайгаар хийж, оршин суух зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх хэсгийн хөгжүүлэлтийг эцэслэж, үйл ажиллагааны бэлэн байдлыг хангав. Хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 09 дүгээр сард 70 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
ГАЗАР